

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2020 оны 100 тоот тушаалын  
7 дүгээр хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЧАНАРЫН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЧАНАРЫН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/Д	ДЭД САЛБАР	ЗОРИЛТ	АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛ
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ	2	6	50%
2	Хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг	2	11	90%
3	Хуулиар нийтлэг олгосон чиг үүрэг	1	8	90%
4	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах хүрээнд	1	4	30%
5	Нэмэлт ажил	2	6	100%
	<b>НИЙТ</b>	<b>8</b>	<b>35</b>	<b>70%</b>

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЧАНАРЫН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл	
					Эхний хагас жил			
<b>НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:</b>								
1	ЗГҮАХ-ийн 3.7.3, НХТЖҮЧ-ийн 9.9.1, НЗДҮАХ-ийн 6.1.11. Барилга байгууламжийг паспортжуулан, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийж, хүчитгэлийн зураг боловсруулж, лаборатори байгуулна.							
1.1	6.1.11.1. 2002 оноос	565.0	Паспортжуулах ажлын жагсаалт, төсвийн задаргаа гаргах, батлуулах;	Жагсаалт, Задаргааны тоо	0	1	2022 онд паспортжуулах 172 барилгын жагсаалтыг гарган, төсвийн задаргаа боловсруулж газрын даргаар батлуулав.	100%
1.2	өмнө баригдсан орон сууц болон олон нийтийн зориулалттай барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах ажлыг үргэлжлүүлэх,		Дүгнэлт гарган, паспортжуулах ажлын үнэлгээний хороо байгуулах, тендерийн баримт бичиг болон ажлын даалгавар боловсруулах, ажил гүйцэтгэх байгууллагыг хууль, журмын дагуу сонгон шалгаруулах;	Тушаалын тоо	0	1	Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/171 дүгээр захирамжийн дагуу Газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн А/04 тушаалаар Барилга байгууламжийг паспортжуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулсан. Орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, олон нийтийн зориулалттай барилгын бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах /газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийх/ 5 багц ажлын даалгавар, тендерийн материал боловсруулан газрын даргаар батлуулав.	100%
			Ажлын даалгаврын тоо	0	5			
			Тендерийн баримт бичгийн тоо	0	1			
1.3		Дүгнэлт гарган, паспортжуулах 5 багц ажил буюу барилгын	Барилгын тоо	840	984	Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Эрх шилжүүлэх тухай” А/171 дүгээр захирамжийн дагуу 172 барилгын	30%	

		хэмжилт, судалгаанд захиалагчийн хяналт тавьж гүйцэтгэлийг хүлээн авах					бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах 5 багц ажил тендерийг 2022 оны 03 оны 01-ний өдрөөс эхлэн 2 удаа зарлаж 1 аж ахуй нэгж үнийн санал ирүүлсэн боловч тендерийн баримт бичгийн иж бүрдэл дутуу, шаардлага хангаагүй учир тендер амжилтгүй болсон. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/2087 дугаар албан бичгийн дагуу төсвийн тодотгол хийж дуусах хүртэл сонгон шалгаруулалтыг түр хугацаагаар зогсоосон.	
1.4		2021 онд хэмжилт судалгаа хийгдсэн 73 барилгын паспортжуулалтын дүгнэлтийг гаргаж дуусгах	-	Барилгын тоо	984	1057	36 барилгад хэмжилт судалгаа хийж, 31 барилгад паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлтийг гаргасан.	50%
1.5	6.1.11.2. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, олон нийтийн барилгын хүчитгэлийн зураг, стандартын	Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, олон нийтийн барилгын хүчитгэлийн зураг боловсруулахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэх санал хүргүүлэх		Хүчитгэл хийх шаардлагатай барилгын судалгаа	JICA судалгаа	1	Монгол Улсын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэх төслийн 2 дугаар үе шатны ажил эхлэхтэй холбоотой 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Япон Улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагын төлөөлөлтэй /Төслийн ахлагч Овада Киётака, Фүкүшима Сэйичиро, н.Наранбаатар/ уулзаж барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчин, бодлого, норм дүрэм, хүчитгэх үйл ажиллагаа, боловсон	50%

	шаардлага хангасан						хүчний чадавхыг бэхжүүлэх талаар санал солилцов.	
1.6	амины орон сууцны нэг маягийн загвар зураг боловсруулахад шаардлагат ай хөрөнгийг шийдвэрлүүлэх санал хүргүүлэх	Стандартын шаардлага хангасан амины орон сууцны нэг маягийн загвар зураг боловсруулах	100.0	Нэг маягийн зургийн тоо	-	10	Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/554 дугаартай захирамжаар Гамшигт тэсвэртэй амины орон сууцны нэг маягийн 10 төрлийн загвар зураг, ажлын зураг төсөл боловсруулах ажилд 100 сая батлагдсан. Сонгон шалгаруулалт зохион байгуулахад шаардлагатай Гамшигт тэсвэртэй амины орон сууцны нэг маягийн ажлын даалгаврыг боловсруулан Нийслэлийн Ерөнхий архитектораар батлуулан Нийслэлийн Худалдан авах, ажиллагааны газарт хүргүүлсэн. Нийслэлийн Худалдан, авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/2087 дугаар албан бичгийн дагуу төсвийн тодотгол хийж дуусах хүртэл сонгон шалгаруулалтыг түр хугацаагаар зогсоосон.	30%
<b>ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД:</b>								
<i>Газрын хөгжлийн зорилтыг хангах ажлын хүрээнд:</i>								
2.1	Газрын стратеги төлөвлөгөөний тухайн жилийн зорилтын хэрэгжилтийг тайлагнаж ажиллах		-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Газрын стратеги төлөвлөгөөний тухайн жилийн зорилтын хэрэгжилтийг тайлагнаж ажиллаж байна. Монгол Улсын Хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөлд нэгжийн үйл ажиллагаанд хамааралтай заалтын дагуу санал	100%

						боловсруулав. Нийслэлийн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний санал боловсруулж Газрын орлогч даргын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 05/151 дүгээр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэв.	
2.2	Барилга байгууламжийг паспортжуулсан дүгнэлтийг бүрэн цахимжуулах	-	Хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэсэн барилгын тоо	840	984	2021 онд паспортжуулсан 15 барилгыг мэдээллийн санд бүртгэв.	50%
<i>Барилгын чанар, аюулгүй байдлыг хангах гамшгаас хамгаалахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд:</i>							
2.3	Нийслэлийн түр орон байраар хангах албаны Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт бэлдэх, бэлэн байдлыг хангах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/59 дүгээр захирамжаар баталсан хуваарийн дагуу түр орон байраар хангах албаны нийт бүрэлдэхүүн, орон тооны бус штабын бэлтгэл бэлэн байдалд нийслэлийн засаг даргын нэрэмжит үзлэг, шалгалт 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулагдаж 81 хүн оролцлоо. Уг үзлэгээр хүн нэг бүрийн үүргэвчинд байвал зохих зүйл, хувцасны жигдрэлт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, сургалт, түр орон байр, хот байгуулалтын мэдээллийн сангийн бэлтгэл, бэлэн байдал зэрэг 17	100%

						үзүүлэлтээр Түр орон байраар хангах албаны даргын баталсан хөтөлбөр, Нийслэлийн онцгой комиссын орлогч даргын 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр баталсан удирдамжаар баталсан үзлэг зохион байгуулах ажлын хэсэг шалгалт хийлсэн бөгөөд 90% буюу А үнэлээ авсан.	
2.4	Газрын гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө хийх	-	Үнэлгээ, төлөвлөгөөний тоо	0	1	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дах хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/247, 2022 оны А/59 дүгээр захирамжийг үндэслэн Газрын даргын 2022 оны А/03 дугаар тушаалаар Түр орон байраар хангах алба гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран Гамшгаас хамгаалах эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх Ажлын хэсгийг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан Нийслэлийн Онцгой байдлын газраас Гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхын үнэлгээний аргачлал сэдэвт сургалт авч багийн бүрэлдэхүүнийг сургаж, дадлагажуулан Нийслэлийн холбогдох байгууллагуудаас ирүүлсэн судалгааны материал, хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн сан, орон нутгийн байгаль орчин, цаг уурын холбогдолтой өгөгдлүүдэд үндэслэн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний тайланг гаргав. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээгээр Байгууллагын эрсдэлийн	100%

						<p>удирдлага, зохион байгуулалт, бодлого, стратеги, төлөвлөгөө, хэрэгжилт хангалтгүй гамшгийн эрсдэлийн чадавх сул үнэлэгдсэн. Санхүүжилт, сэргээн босголтын нөөц зарцуулалт, эрсдэлийн менежментийн бодлого хангалтгүй байна. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний 5 онооноос 2.13 буюу 43%-иар үнэлэгдсэн эрсдэлийн түвшин өндөр гарсан байна.</p> <p>Дайчилгаа, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг албаны онцлогт тохируулан боловсруулан Нийслэлийн Орон сууцны корпораци ХК, Нийслэлийн Боловсролын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газраас санал авч газрын даргаар батлуулав.</p>	
2.5	Нийслэлийн түр орон байраар ашиглах барилгуудын жагсаалтыг тодотгох батлуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	<p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/499 дүгээр захирамжаар болзошгүй гамшгийн үед ашиглах түр орон байрны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогч Б.Сүхбаатар 2022 оны 05 дугаар сарын 12-ний өдөр ажлын хэсгийг хуралдуулж Түр орон байрны судалгааг газар дээр нь судлах үүрэг даалгавар өгсөн.</p>	100%



						<p>Үүргийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр газар дээр нь ажиллаж судалгааг ирүүлэх тухай 02-05/2612, 02-05/2613 дугаартай албан бичгийг Нийслэлийн Аялал жуулчлалын газар болон Дүүргийн Засаг дарга нарт хүргүүлсэн.</p> <p>Одоогоор Нийслэлийн Аялал жуулчлалын газар болон 7 дүүргээс судалгаа ирүүлсэн нэгтгэх ажил хийгдэж байна</p>	
2.6	Нийслэлийн түр орон байраар хангах албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэх	-	Шинэчилсэн төлөвлөгөөний тоо-1	1	1	Газрын даргын 2022 оны А/19 дүгээр тушаалаар түр орон байраар хангах албаны Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн томилгоонд тодотгол хийж, бэлэн байдлыг хангуулсан. Зарлан мэдээллийн дохио дамжуулах бүдүүвчийг албаны хэмжээнд нарийвчлан гаргав.	100%
2.7	Барилга, байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт /паспортжуулах/ төлбөртэй хэмжилт, судалгаа хийж, дүгнэлт гаргах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	6 барилгад хэмжилт судалгаа хийж, төлөв байдлын дүгнэлт гарган улсын төсөвт 5.4 сая төгрөгийн хөрөнгө оруулсан.	100%
2.8	Нийслэлийн орон тооны бус паспортжуулалтын зөвлөлийг шинэчлэн байгуулах, Зөвлөлийн үйл ажиллагааны журмыг боловсруулан батлуулах	-	Захирамж, Журмын тоо-1	-	2	Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 129 дүгээр тушаалаар баталсан “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ын 4.8 дах заалтын дагуу Нийслэлийн Засаг даргын А/365 дугаар захирамжаар Нийслэлийн орон тооны бус паспортжуулалтын зөвлөлийг шинэчлэн байгуулан, Паспортжуулалтын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг батлуулав.	100%

2.9	Нийслэлийн орон тооны бус паспортжуулалтын зөвлөлийн хэлэлцэх асуудлын жагсаалт, төлөвлөгөөг боловсруулах, хурлын бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, үйл ажиллагааг тасралтгүй хангах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Нийслэлийн орон тооны бус паспортжуулалтын зөвлөлийн хэлэлцэх асуудлын жагсаалт, төлөвлөгөө гараагүй байна.	100%
2.10	Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөл, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Нийслэлийн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний санал боловсруулж Газрын орлогч даргын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 05/151 дүгээр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэв.	70%
2.11	Одон, орон геофизикийн хүрээлэнтэй хамтарч Газар хөдлөлтийн чичирхийлэл бичигч GSR-24 багажаар байнгын хэмжилт, судалгаа хийх, найдвартай ажиллагааг хангах	-	Танилцуулга	0	1	Одон орон, геофизикийн хүрээлэнгээс 2021 оны 170 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Хүчтэй газар хөдлөлтийн баллыг тодорхойлох багаж, төхөөрөмжийг Улаанбаатар хотын 4 бүсэд суурилуулан урт хугацаанд хамтран хэмжилт, судалгаа хийж байна.	100%
<b>ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:</b>							
3.1	3.1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын дагуу бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хяналтад авсан заалтын	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%

	хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах						
3.2	3.2.Хэлтсийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, жилийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн Монгол орны газар хөдлөлтийн өнөөгийн нөхцөл байдал, анхаарах зүйлс, урьдчилан сэргийлэх асуудлын талаар Барилга, хот байгуулалтын яам, Онцгой байдлын ерөнхий газар, Одон орон геофизикийн хүрээлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтарсан хэвлэлийн хуралд хэлтсийн дарга Н.Тамир оролцож Барилга байгууламжийн паспортжуулалтын талаар сүүлийн үеийн мэдээ, мэдээлэл өгөв.	100%
3.3	3.3.Газрын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Нийслэлийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 10 гаруй олон нийтийн сайтуудаар болон Нийслэл мэдээ, ТВ-5, UBS зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар мэдээлэл бэлдүүлж 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдөр олон нийтэд түгээв.	70%
3.4	3.7. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/01 захирамжийн хүрээнд Орон сууцны барилгад дур мэдэн хийсэн зориудын өөрчлөлтөөс гамшгийн дараа үүсэж болох сөрөг нөлөөллийн талаар иргэдэд сургалт явуулах, таниулах материал бэлдэх, сурталчлах	-	Сургалтын тоо	3	4	Сургалтын танилцуулга бэлтгэл ажлыг ханган, тараах материал бэлтгэх зардлыг удирдлагуудад танилцуулахаар ажиллаж байгаа бөгөөд сургалтыг 9 дүүргийн хэмжээнд энэ оны 3 дугаар улиралд зохион байгуулахаар ажиллаж байна.	30%
3.5	3.13. Хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх, Төрийн албаны зөвлөл болон Газрын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдах	-	Сургалтад хамрагдсан цаг /1 албан хаагч/	1 албан хаагчийн сургалт	1 албан хаагчийн сургалтад хамрагдах цаг	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7:4:10” арга зүйн сургалтуудад бүх албан хаагчид хамрагдсан. 1 албан хаагчийн сургалтад хамрагдсан дундаж нь 20	50%

					ад хамрагдсан цаг /дунджаар 60 цаг/	/дунджаар 40 цагаас багагүй байх /	цаг байна. 1 албан хаагч Мэргэшсэн зэрэг горилох сургалтанд хамрагдаж 2кр цаг цуглуулсан. “Бетоны технологи” сэдэвт Японы JSCE Бетоны холбооны 3 дахь вебинар онлайн сургалтад хамрагдаж “Барилга, байгууламжийн геотехникийн асуудлууд” эрдэм шинжилгээний хуралд оролцсон. Үндэсний итгэмжлэлийн төвөөс зохион байгуулж буй Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018 сэдэвт сургалтад 2022 оны 06 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд хамрагдахаар бүртгүүлсэн.	
3.6	Архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэж ажиллах	3.10.1 Албан бичгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэлтийг чанаржуулах	-	Шийдвэрлэлт хугацаа, хоног	9 хоног	8 хоног	2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар иргэн, аж ахуйн нэгжээс UB.EDOC системээр нийт-104 албан бичиг ирүүлснээс 103 албан бичгийг шийдвэрлэсэн. Судалж байгаа 1 байна. Шийдвэрлэлтийн хоног-9.21	100%
		3.10.2 Албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин, зөрчил гаргасан албан хаагчдыг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах	-	Гарсан шийдвэрийн тоо	-	1	Одоогоор зөрчил гаргасан албан хаагч гараагүй.	100%
		3.10.4 Ирсэн, явуулсан бичгийн бүртгэлийг EDOC системээс хэвлэн, архивлах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлээр	100	100	Ирсэн, явуулсан бичгийн бүртгэлийг EDOC системээс хэвлэн, архивлан ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр	100%

		- Ирсэн бичгийн бүртгэл хяналтын картыг хэвлэх, цахимаар ирсэн бичгийг бүртгэл хяналтын картын хамт EDOC системээс хэвлэн, архивлах (үндсэн үйл ажиллагааны чиглэлээр)					захирамжаар бүтэц орон тоог шинэчлэн зохион байгуулсантай холбоотойгоор 2021 онд Барилгын ажлын зөвшөөрөл олгосон бүх барилгын жагсаалтыг шинэчлэн Хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэж, шинээр ирсэн хүсэлттэй хамт Хот байгуулалтын инженерийн бэлтгэл, хяналтын хэлтэст хүлээлгэж өгсөн.	
		3.10.5 Албан бичгийн цахим архив үүсгэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт гүйцэтгэлээр	Үгүй	Тийм	Албан бичгийг боловсруулалтын цахим архив үүсгэн ажиллаж байна.	100%
3.7	Өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллах	Шийдвэрлэлтэд хууль зүйн үндэслэлийг тусгаж, эцэслэн шийдвэрлэх	-	Шийдвэрлэлт хугацаа, хоног	9 хоног	8 хоног	2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар иргэн, аж ахуйн нэгжээс UB.EDOC системээр 14 өргөдөл, гомдол ирснийг 17 хоногийн хугацаанд шийдвэрлэсэн.	100%
3.8	3.16.Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг батлагдсан хуваарьт хугацаанд холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгөх		-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	2021 оны үйл ажиллагааны баримт бичгийн 24 боть материалыг бэлдэж хүлээлгэн өгөв. Газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн “Архивын баримтад нягтлан шалгах ажлын хэсэг байгуулах тухай” А/30 дугаар тушаалын дагуу 580 хавтаст материалыг нягтлан шалгаж, засаж сайжруулав.	100%
<b><u>ДӨРӨВ .ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД:</u></b>								
4	Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр иргэн, хуулийн этгээдэд барилга, хот байгуулалт, дахин төлөвлөлт, газар орон зайн мэдээлэл, дэд бүтэц, барилга байгууламжийн ашиглалтын аюулгүй байдлын чиглэлээр үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, ухаалаг технологийг нэвтрүүлэн шийдвэрлэнэ.							
4.1	Газрын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд I-UP мэдээллийн цонхыг тогтмол ажиллуулах	-	I-UP мэдээллийн цонхонд мэдээ мэдээлэл	1	1	Газрын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэхээр мэдээлэл бэлдэж байна	50%	

			байршуулсан тоо				
4.2	Барилга байгууламжийн ашиглалтын аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулах	-	Сургалтын тоо	-	1	Сургалтыг 3 дугаар улиралд хийхээр төлөвлөсөн.	30%
4.3	Барилгын мэргэшсэн инженерийн сургалт	-	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	1	1	4 дүгээр улирлын хуваарьт сургалтад хамрагдахаар төлөвлөсөн.	0%
4.4	Мэргэшсэн төсөвчний сургалтад хамрагдах	-		0	1	4 дүгээр улирлын хуваарьт сургалтад хамрагдахаар төлөвлөсөн.	0%

#### ХОЁР. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт	Гүйцэтгэл
1	2	3	4	
<b>НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ</b>				
2.1	Цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор өгч буй үүрэг даалгавар	Нийслэлийн Ерөнхий Архитектор	Нийслэлийн Ерөнхий Архитектораас өгсөн үүрэг даалгаврын дагуу Богд хааны зуны ордон /Хайстайн лаврин ордон/ болон Гоожингийн өндөр зэрэг түүхэн дурсгалт барилгыг нүүлгэн, шилжүүлэх судалгаа хийж, танилцуулга бэлдэв.	100%
2.2	Цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор өгч буй үүрэг даалгавар	Нийслэлийн Ерөнхий Архитектор	Төрийн үйлчилгээний шинэчлэл, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийн талаар судалгаа хийж танилцуулга бэлдэв.	100%
2.3	Цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор өгч буй үүрэг даалгавар	Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 02-05/68 дугаар албан бичиг	Барилга, байгууламжийг паспортжуулах, Ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган шинээр барих үйл ажиллагаа, 2022 онд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээний талаарх танилцуулга бэлдэж, Нийслэлийн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн эхний хуралд газрын дарга танилцуулга хийв.	100%
2.4	Цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор өгч буй үүрэг даалгавар	Нийслэлийн Онцгой байдлын газар	Түр орон байрны хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хэсэг байгуулахаар Нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулан батлуулав.	100%

2.5	Цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор өгч буй үүрэг даалгавар	Нийслэлийн Засаг даргын барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогчийн 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдөр баталсан удирдамж	Удирдамжийн дагуу болзошгүй гамшиг ослын үед ашиглах нүүлгэн шилжүүлэх байршил, түр цугларах талбайн үзлэг, шалгалтыг Сонгинохайрхан, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулан үр дүн, санал дүгнэлтийг албан бичгээр Нийслэлийн Онцгой байдлын газарт хүргүүлсэн.	100%
2.6	Цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор өгч буй үүрэг даалгавар	Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Онцгой байдлын газар	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны “Барилга, байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх байдалд хийсэн үнэлгээний явц, үр дүнгийн дагуу авах зарим арга хэмжээний тухай” 17/08 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг гаргаж Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Онцгой байдлын газарт хүргүүлэв.	100%

Төлөвлөгөөг үнэлсэн: **Төсвийн шууд захирагч**

Хот байгуулалт хөгжлийн газрын дарга ..... /Ц.ТУЛГА /  
(огноо)

.....

Тэмдэг

.....

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Үнэлгээний багийн дарга ..... /Ч.БАДАМХАНД/  
(огноо)

.....

Тайлагнасан:

Барилга байгууламжийн чанарын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч ..... /Н.ТАМИР/  
(огноо)

